



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А1379

Номгон

Иргэн Б.Сүнгэрийн эзэмшил газрын
зөрчил арилгах тухай


Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Газрын харилцааны талаар авах арга хэмжээний тухай” 135 дугаар тогтоолын 1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэн Б.Сүнгэрийн /ВЭ48070201/ Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалттай 54 м2 газрын талбайн хэмжээ зөрүүтэй байгаа тул зөрчлийг арилган илүү эзэмшиж буй 27 м2 газрын үнийг төлүүлж нэмж эзэмшүүлж хавсралтаар баталсугай.

2.Эзэмшил газрыг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл), эзэмшил газарт Улсын бүртгэлийн “Э” дугаар олгохыг Улсын бүртгэлийн хэлтэс (Ц.Мөнхжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.


3.Эзэмшил газрыг зориулалтын дагуу зүй зохистой ашиглаж цаашид дээрх зөрчлийг гаргахгүй байхыг иргэн Б.Сүнгэрт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

621010953

Аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын
11-ний өдрийн А/379 дүгээр захирамжийн хавсралт



ЭЗЭМШИЛ ГАЗРЫН ТАЛБAYН ХЭМЖЭЭ ӨӨРЧЛӨДӨЖ
БАЙГАА ИРГЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

д/д	Газар эзэмшигчийн нэр	Регистрийн дугаар	Нэгж талбарын дугаар	Зориулалт	Хаяг	Талбайн хэмжээ /м2/	Залруулгаар нэмэгдэж байгаа талбайн хэмжээ /м2/	Нийт талбайн хэмжээ
1	Б.Сүнгэр	ВЭ48070201	040700265- 064	Худалдаа нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	Баянхонгор сум, Номгон 1-р баг, Худалдааны гудамж-5, 541 тоот	54 м2	27 м2	81 м2

_____оОо_____